## АГУУЛГА


1 .ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА ..... 3

1.1 Оршил ..... 3
1.2 Үйл ажиллагаа явуулж буй газрын засаг захиргааны харъяалал ..... 3
1.3 Уурхайн байршил ..... 3
1.4. Ил уурхайн ажиллах горим ..... 5
1.4.1. Уулын ажлын олборлолт календарчилсан төлөвлөгөө ..... 5

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ..... 6

2.1 Газар зүй ..... 6
2.2 Байгаль, цаг агаар ..... 6
2.3 Нийгэм эдийн засгийн ерөнхий мэдээлэл ..... 6
2.3.1 Байгалийн нөөц. ..... 6

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ..... 7

4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ ..... 9

4.1 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зорилт, хамрах хүрээ ..... 9

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 10

5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ..... 15
5.2 Гадаргын болон газрын доорхи усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ ..... 17
5.3 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ..... 17
5.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ..... 18
5.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ..... 19

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 21

6.1. Техникийн нөхөн сэргээлт ..... 21
6.2. Биологийн нөхөн сэргээлт, туршилт ..... 22

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 26

9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 26

10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 27

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 29

12.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ................................ 32
12.1. Агаарын чанарын хяналт шинжилгээ ........................................ 33
12.2. Усны чанарын хяналт шинжилгээ ........................................ 34
12.3. Хөрсний хяналт шинжилгээ ........................................ 35
12.4. Амьтан, ургамлын мониторинг ........................................ 35
13. ТУХАЙН ЖИЛИЙНИ БОМТ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ........................................ 37
14. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-ИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ........................................ 38
15. БОМТ-ИЙН НИЙТ ЗАРДАЛ ........................................ 39

Хүснэгт№ 1. Компанийн мэдээлэл ........................................ 3
Хүснэгт№ 2.Лицензийн байршил, солбицол ........................................ 5
Хүснэгт№ 3. Хөрс хуулалтад шаардагдах тэсрэх материалын зарцуулалтын тооцоо ............. 5
Хүснэгт№ 4. *Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний товч тодорхойлолт* ........................................ 7
Хүснэгт№ 5. Агаарын чанарын сөрөг нөлөөлөл ........................................ 11
Хүснэгт№ 6. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл ........................................ 12
Хүснэгт№ 7. Газрын гадарга газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл ........................................ 12
Хүснэгт№ 8. Ургамлан нөмрөг үзүүлэх сөрөг нөлөөлөл ........................................ 13
Хүснэгт№ 9. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ........................................ 13
Хүснэгт№ 10.Амьтны аймаг үзүүлэх сөрөг нөлөөлөл ........................................ 14
Хүснэгт№ 11. Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө ........................................ 15
Хүснэгт№ 12.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө ........................................ 23
Хүснэгт№ 13.Дүйцүүлэн хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд ........................................ 25
Хүснэгт№ 14.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ ............................... 26
Хүснэгт№ 15. Түүх соёлын өвийг хамагаалах арга хэмжээ ........................................ 26
Хүснэгт№ 16. Осол эрсдэлийн менежментийн төлловлөгөө ........................................ 27
Хүснэгт№ 17. Хог хаягдлын менежмент ........................................ 30
Хүснэгт№ 18. Агаарын чанарын хяналт шинжилгээ ........................................ 33
Хүснэгт№ 19.Усны чанарын хяналт шинжилгээ ........................................ 34
Хүснэгт№ 20. Хөрс, ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээ ........................................ 35
Хүснэгт№ 21. Ургамал, амьтны аймгийн хяналт шинжилгээний хөтөлбөр ......................... 35
Хүснэгт№ 22. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ........................................ 37
Хүснэгт№ 23. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвөгөө ......................... 38
Хүснэгт№ 24. БОМТ-ийн зардлын дүн ........................................ 39

Зураг№ 1. Төслийн байршил ........................................ 4
Зураг№ 2. Алаг Цав чулуун нүүрсний уурхай ........................................ 4
Зураг№ 3. Уурхайн үйл ажиллагаагаас ялгарах TSP, PM2.5 тоосны тархалтын агууламж, мкг/м$^3$ ........................................ 11
Зураг№ 4. Техникийн нөхөн сэргээлт хийх төлөвлөлт ........................................ 21
Зураг№ 5. Дүйцүүлэн хамгаалалт хийхээр төлөвлөж буй газрын байршил ......................... 24

# 1 .ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Оршил

Төсөл хэрэгжүүлэгч "Их түмэн хүрд" ХХК нь Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дэвсгэрт орших MV-021559 (932.13 га) тоот тусгай зөвшөөрлийн талбай бүхий "Түмэн айл" чулуун нүүрсний ордын баруун жигүүрт 2015-2017 онд хайгуулын ажил гүйцэтгэсэн. Ордын бохир чулуун нүүрс бодитой болон боломжтой нөөцийг 61977.85 мян.тн, цэвэр чулуун нүүрс бодитой блон боломжтой нөөцийг 59859.99 мян.тн-оор ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд ЭБМЗ-ийн 2019 оны 12-р сарын 10-ны өдрийн XX-18-04 тоот дүгнэлт, АМГТГ-ын даргын 2020 оны 2-р сарын 5-ны өдрийн н/10 тоот тушаалаар бүртгэж авсан байна.

Энэхүү бүртгүүлсэн нөөцөөс олборлолт явуулж ордын 2025 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаарх үлдэгдэл нөөц баттай (A) зэрэглэлээр нүүрсний нөөц 30'578.14 мян.тн, бодитой (B) зэрэглэлээр нүүрсний нөөц 29'472.36 мян.тн, нийт (A+B) зэрэглэлээр нүүрсний нөөц 60'050.5 мян.тн байна.

"Түмэн айл" чулуун нүүрсний ордын баруун урд жигүүрийг ил уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг тус ордод гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ЭБЭХ-ний Сайдын 2012 оны 4-р сарын 17-ны өдрийн дугаар 074 тушаалаар батлагдсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник эдийн засгийн үндэслэлд тавигдах шаардлагууд ба техник эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам" зэргийг үндэслэн "Ляпислазурь эрдэнэ" ХХК боловсруулсан байна.

## 1.2 Үйл ажиллагаа явуулж буй газрын засаг захиргааны харъяалал

*Хүснэгт№ 1. Компанийн мэдээлэл*

| Төсөл хэрэгжүүлэгчийн нэр | Улсын бүртгэлийн дугаар | Регистрийн дугаар | Үйл ажиллагааны чиглэл | Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг |
|---|---|---|---|---|
| "Их Түмэн Хүрд" ХХК | 9011778053 | 6375839 | Нүүрсний олборлолт | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, 5-р хороолол, Нарны зам, Жигүүр гранд оффис 5-11 тоот |

## 1.3 Уурхайн байршил

Дорноговь аймгийн Мандах сумын төвөөс урагш 30 км, Сайншанд хотоос баруун урагш 200 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 484 км, МУ-БНХАУ хилийн Ханги-Мандал боомтоос баруун хойш 235 км-т байрлалтай.




*Зураг№ 1. Төслийн байршил*




*Зураг№ 2. Алаг Цав чулуун нүүрсний уурхай*

*Хүснэгт№ 2.Лицензийн байршил, солбицол*

| Тусгай зөвшөөрлийн дугаар | Олгогдсон Он, сар, өдөр | Хугацаа (жил) | Цэгийн дугаар | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|---|---|---|
| Газрын солбилцол L-49-133 | | | | | |
| MV-021559 (932.13 га) | 2024-04-01 | 30 | 1 | 108⁰16’50.13” | 44⁰07’51.05” |
| | | | 2 | 108⁰16’50.13” | 44⁰09’20.35” |
| | | | 3 | 108⁰14’18.03” | 44⁰09’20.35” |
| | | | 4 | 108⁰14’18.03” | 44⁰07’51.05” |

## 1.4. Ил уурхайн ажиллах горим

Уурхайн ажиллах горимыг захиалагч байгууллагын техникийн даалгавар, уурхайн жилийн хүчин чадалтай нь уялдуулан дараах байдлаар сонгов. 2026 онд 01-р сарын 01-аас 12-р сарын 31-ний хооронд 365 хоногийн турш, өдрийн 2 ээлжээр ажиллахаар төлөвлөж байна. Уулын ажлын олборлолт календарчилсан төлөвлөгөө 2026 онд Календарчилсан төлөвлөгөөг уурхайн жилийн хүчин чадал, төслийн даалгаврыг үндэслэн эхний жилд 6.0 сая тн нүүрс олборлохоор байна.

### 1.4.1. Уулын ажлын олборлолт календарчилсан төлөвлөгөө

2025 онд нийт 7529,30 мян.м3 хөрс хуулалтын ажил хийгдэнэ. 3-2, 3-3 ,4-1,4-2 давхаргуудын 58А, 66В, 75В, блокуудаас 1000.0 мян.тн чулуун нүүрс олборлохоор төлөвлөсөн.

*Хүснэгт№ 3. Хөрс хуулалтад шаардагдах тэсрэх материалын зарцуулалтын тооцоо*

| № | Материалын нэр | Хэмжих нэгж | 2026 он |
|---|---|---|---|
| 1 | Хөрс хуулалт | **мян.м$^3$** | 123585.1 |
| 2 | Тэсрэх бодис, анфо, эмүльс | тн | 7853.01 |
| 3 | Нонель | ш | 72412.51 |
| 4 | Цочир дамжуулах шижим, ДША | М | 192527.55 |
| 5 | Өдөөгч | Ш | 34740.05 |
| 6 | Цахилгаан тэслүүр | Ш | 2717 |
| 7 | Хором удаашруулагч | ш | 44603 |
| 8 | Өрөмдлөгийн урт | **мян.м$^3$** | 599.29 |

# 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

## 2.1 Газар зүй

Дорноговь аймаг нь Монголын зүүн өмнөд хэсгийн талархаг гадаргатай хэсэгт оршдог. Гэхдээ Хутаг уул (1431м), Оцол, Сансар, Их Багадулаан, Аргалант, Хан Баянзүрх хайрхан (1031м) зэрэг уулууд бий. Нутгийн дундуур зүүн хойшоо баруун урагшаа их хотгор газар үргэлжилнэ. Дорноговь аймгийн нутагт том гол мөрөн, нуур байхгүй, харин газар доорхи усны их нөөц бий. Халзан уул, Бусийн Чулууны, Толь булгийн зэрэг рашаан устай. Нутгийн ихэнхэд говийн бор хөрс тархсан бөгөөд элс нилээд байдаг.

## 2.2 Байгаль, цаг агаар

Тус аймаг бүхэлдээ говийн бүсэд хамаардаг, говь хээр хосолсон нутагтай. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, зуны улиралд +41 хэм хүртэл халж, өвлийн улиралд -40 хэм хүртэл хүйтэрдэг. Салхины дундаж хурд 4,2-4,6 м/сек, зарим үед 35 м/сек хүртэл ширүүсэх тохиолдол бий. Цаг агаарын тааламжгүй нөлөөлөл болох хүчтэй цасан ба шороон шуурга, ган, зудын аюул цөөн бус удаа тохиодог, сүүлийн жилүүдийн хуурайшилтын улмаас цөлжилтийн явц хурдасч байна. Говийн эмзэг байгалийг нөхөн сэргээх боломж хязгаарлагдмал. Гадаргын усны нөөц бараг үгүйгээс гүний усыг татаж ахуй амьдрал болон мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд ашигладаг.

## 2.3 Нийгэм эдийн засгийн ерөнхий мэдээлэл

Мандах сум нь 1924 оны 08 дугаар сарын 01-ний өдөр үүсгэн байгуулагдсан. Засаг захиргааны 5 багтай. Дорноговь аймгийн баруун хэсэгт байрлан, зүүн талаараа- Сайхандулаан, урд талаараа- Хөвсгөл, Хатанбулаг, Улаанбадрах, баруун талаар- Өмнөговь аймгийн Манлай, хойд талаараа- Өндөршил, баруун хойд талаараа- Дундговь аймгийн Өлзийт сум оршдог  Мандах сум 500 өрх, 1585 суурин хүн амтай.

Сумын газар нутгийн нийт хэмжээ 1,266,061.00  га. Газрын нэгдмэл сангийн ангилалаар нь хувааж үзвэл:

- Хөдөө аж ахуйн эдэлбэр газар – 1,128,075.02 га
- Хот тосгоны эдэлбэр газар – 9,546 га
- Усны эдэлбэр газар – 1,661.00 га
- Тусгай хамгаалалттай газар – 84,146 га
- Зам, шугам сүлжээний газар – 45,80 га байна.

### *2.3.1 Байгалийн нөөц.*

Сумын нутаг Цагаан суварга, Хөнгөөтийн зэсийн нөөц орд, хоньчийн нүүрсний орд, алт, усан утаат болор, жонш, өнгөт боржин, занар, гипс, шохой, нүүрс, шороон будгийн арвин нөөцтэй. Тус сумын нутагт Цагаан цавын гүний усны нөөцтэйгээс гадна зүүн, баруун сухай, Наран, Толь, Гэр чулуу, Гишүүнтэй зэрэг томоохон булаг ус элбэгтэй бүрд тойром олонтой.

# 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймгийн Мандах сумын нутагт хэрэгжиж буй "Их түмэн хүрд" ХХК-ний нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг төслийн ерөнхий үнэлгээгээр тодорхойлсон байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг тус тайлангийн үнэлгээний үндэслэл болгон авч үзсэн.

Байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд тодорхойлсон агаар, усан орчин, хөрсөн бүрхэвч, ургамал, амьтан зэрэг байгаль орчны бүрдэл хэсгүүд, нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд тодорхойлсон нутгийн оршин суугчид, түүх соёлын биет өв, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө төслийн техногений үйл ажиллагааны дараах нөхцлүүдтэй холбоотой байна.

Хүснэгт№ 4. *Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний товч тодорхойлолт*

| **Сөрөг нөлөөлөл үүсч болзошгүй нөхцөлүүд** | **Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ** |
|---|---|
| **Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ** | |
| Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл:<br>✓ Уул уурхайн олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас агаар орчныг бохирдуулна.<br>✓ Хүнд даацын машин техникийн хөдөлгөөнөөр агаар орчинд тоосжилт, хорт хий, дуу чимээ үүснэ.<br>✓ Шороон зам, талбайгаас тоосжилт үүсэх<br>✓ Цахилгаан, дулаан хангамжын техник хэрэгслээс дуу чимээ үүснэ. | ✓ Уурхайн олборлолт, тээвэрлэлтийн үед уурхайн шүүрлийн ус ашиглаж тоосжилт дарах усалгаа хийх<br>✓ Уурхайгаас төв авто зам хүртлэх тээврийн зам болон машин паркын талбайг тогтмол арчлах.<br>✓ Машин техникийн хорт хийн агаар шүүгчийг тогтмол шинэчилж байх.<br>✓ Хог хаягдлыг удаан хадгалахаас зайлс хийх, зориулалтын талбай, саванд хадгалах. |
| Усан орчинд үзүүлэх нөлөөлөл:<br>✓ Ажилчдын кемпийн ахуйн хэрэглээ болон зам талбайн усалгаанд гүний худаг болон шүүрлийн ус ашиглана. Гүний усны нөөцөд шууд нөлөө үзүүлнэ. | ✓ Тоосжилт дарах бодис ашиглаж усалгаанд ашиглах гүний усны хэрэглээг бууруулах, усны нөөц хэмнэх.<br>✓ Тоолуурын заалтаар ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөх.<br>✓ Ахуйн хэрэглээнд гүний усыг зүй зохистой ашиглах. |

| | |
|---|---|
| Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөө:<br>✓ Уурхайн ухсан нүх, гадаад овоолго, зам, талбай, суваг, шуудуу үүсч хөрс онцгой их эвдрэлд орох.<br>✓ Хөрсний үржил шимт нөөц нь багасах,<br>✓ Хөрсний өнгөн хэсэг нүүрс, тоосжилт, ахуйн хог болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдох. | ✓ Уурхайн хаалтын төлөвлөгөө, ТЭЗҮ, БОННҮ-д техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг нарийвчилан төлөвлөх, төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлт хийх.<br>✓ Эвдрэлд орох талбайн үржил шимт хөрсийн стандартын дагуу хуулан авч овоолго үүсгэн хадгалах, овоолгыг хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх.<br>✓ Олон салаа зам үүсэхээс урьдчилан сэргийлэх<br>✓ Ахуйн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүнээр хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх.<br>✓ Асгаралтаас сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлэх.<br>✓ Ахуйн шингэн хаягдал зайлуулах дэвшилтэд технологи ашиглах. |
| Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө:<br>✓ Уурхайн олборлолт, барилга байгууламж барих, зам талбай засах, олон салаа зам үүсэх үед ургамлан бүрхэвч дарагдах, устах гол сөрөг нөлөөтэй.<br>✓ Тоосжилт, хүн, техникийн нөлөөгөөр орчны ургамлан бүрхэвч талхлагдах, | ✓ Уурхайн хаалтын төлөвлөгөө, ТЭЗҮ, БОННҮ-д биологийн нөхөн сэргээлтийг нарийвчилан төлөвлөх, төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлт хийх.<br>✓ Шинээр барилга байгууламж барих, зам, талбай засах, суваг шуудуу татах зэрэгт өртөх ховор болон ашигт эмийн ургамлыг нүүлгэн |
| ургамлын нөөц багасах болзошгүй сөрөг нөлөөтэй. | шилжүүлэх.<br>✓ Тоосжилт, олон салаа зам үүсэх зэргээс урьдчилан сэргийлснээр ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна. |
| Ан, амьтанд үзүүлэх нөлөө:<br>✓ Уурхайн үйл ажиллагаа, хүнд даацын машин техникийн хөдөлгөөний улмаас зэрлэг амьтдын амьдрах орчин хязгаарлагдах.<br>✓ Амьтдын бүлгэмдэлд өөрчлөлт орох, улмаар зарим зүйл амьтдын тоо толгой, нүүдэл шилжилтэнд сөргөөр нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөтэй. | ✓ Амьтны шилжилт хөдөлгөөнийг анхааруулсан замын тэмдэг тэмдэглэгээ байршуулах<br>✓ Цахилгааны утсанд шувууны хамгаалалт хийх, шувуу суух зориулалт бүхий суулт байршуулах.<br>✓ Нэн ховор, ховор ан амьтанд өвлийн улиралд идэш тэжээл өгөх.<br>✓ Нэн ховор, ховор ан амьтныг хамгаалах, хулгайн антай тэмцэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх. |
| **Нийгмийн нөлөөллийн үнэлгээ** | |
| ✓ Бэлчээрийн газрын хомсдол үүсэх<br>✓ Орчны бохирдолоос малчдын амьдрах орчин, малын бэлчээрт бохирдол үүснэ. | ✓ Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсэнээр малчдын амьдрах орчин, бэлчээрийн газрын бохирдлоос урьдчилан сэргийлнэ.<br>✓ Малчдад өвс тэжээл, эрүүл мэндийн чиглэлээр дэмжлэг үзүүлэх |

| | |
|---|---|
| Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө:<br>✓ Төслийн нөлөөллийн бүсэд байгаа нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.<br>✓ Ажиллагсдын эрүүл мэндэд шууд нөлөө үзүүлнэ. | ✓ Уурхайгаас үүсэх тоосжилт, дуу чимээ зэрэг сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч нутгийн иргэд, мал аж ахуй, бэлчээрт үзүүлэх нөлөөллийг бууруулах.<br>✓ Ажиллагсдын хөдөлмөрийн багаж хэрэгслээр бүрэн хангах<br>✓ Хөдөлмөрийн хүнд нөхцөлтэй уялдуулсан удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх<br>✓ Шууд нөлөөллийн бүсэд орших оршин суугчдын эрүүл мэндэд хяналт тавих, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, дэмжлэг үзүүлэх, нөхөн олговор олгох. |

# 4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

## 4.1 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зорилт, хамрах хүрээ

"Их Түмэн Хүрд" ХХК-ийн Алаг Цав уурхайн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь уг төслийн үйл ажиллагаа эрхлэн явуулах бүхий л үе шатыг хамрах ба гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах арга хэмжээ буюу төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан БОМТөлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмыг баримтлан боловсруулсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, техникийн нөхөн сэргээлт, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ, осол эрсдлийн менежмент, хог хаягдлын менежент, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин сууугчдад тайлагнах зэрэг төлөвлөгөөнүүд багтсан.

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд **..............** төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримтлах арга зүй, стандарт, холбогдох эрх зүйн баримт бичгийн заалт, зардлын задаргааг тусгав.

***Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:***

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд:

- Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ус, амьтан, ургамалд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
- Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичиг, стандартыг тодорхойлох
- Шаардлагатай хөрөнгө, зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох
- Дүйцүүлэн хамгааллаар гүйцэтгэх ажил, “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тухайн орон нутагт мод тарих ажлыг орон нутгийн саналыг үндэслэн чанартай хийж гүйцэтгэх зэрэг орно.

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Алаг Цав уурхайн олборлолтын үйл ажиллагааны үе шатанд гарч болох гол сөрөг нөлөөллүүдийг урьдчилсан байдлаар тодорхойлсны хүрээнд Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөг боловсруулллаа.

Уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг тэргүүлэх чиглэл болгон авч үзэж хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зарчмыг баримтлан ажиллах бөгөөд дараах арга хэмжээнүүдийг авч ажиллана. Үүнд:

- Монгол улсын холбогдох хууль тогтоомж стандартууд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хариуцлагатай, байгаль орчинд ээлтэй туршлагуудыг хэрэгжүүлж ажиллах
- Нийтээр дагаж мөрдөх байгаль орчны бодлого, хууль, тогтоомжид нийцүүлэн төслийн бүх үйл ажиллагааг явуулна.
- Төслийн Байгаль орчны удирдлагын тогтолцоо нь тус уурхайн бизнес төлөвлөгөөний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тасралтгүй хэрэгжүүлж ажиллана.

Төслийг хэрэгжүүлэхэд уурхайн дэд бүтцийн барилга байгууламж, тоног төхөөрөмжүүдийн угсралт, бүтээн байгуулалтын үе шат болон уурхайн ашиглалтын үйл ажиллагааны бүх үе шатанд төслийн талбайн байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг арилгах, багсгах, бууруулах дараах арга хэмжээнүүдийг авч ажиллана. Үүнд:

## Байгаль орчин үзүүлэх сөрөг нөлөөл

Төслөөс байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан илрүүлж, түүнээс сэргийлэх, бууруулах, арилгахад чиглэгдэнэ.

Байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах хэсгүүдэд ангилан авч үзэв. Үүнд:

- Агаар

- Газрын гадарга, хөрс
- Гадаргын болон газрын доорх ус
- Ургамлан нөмрөг
- Амьтан

Агаарт үзүүлэх сөрөг нөлөөлөл




*Зураг№ 3. Уурхайн үйл ажиллагаагаас ялгарах TSP, PM2.5 тоосны тархалтын агууламж, мкг/м$^3$*

Агаарын чанарын нөлөөллийн бүс: Агаарын чанарын нөлөөллийн бүсийг тогтооход Агаарын чанарын стандартын техникийн шаардлага MNS 4585:2016 стандартын PM10 тоосны жилийн хүлцэх агууламж болох 50 мкг/м$^3$-иас 2 дахин буурах агууламж болох 25 мкг/м$^3$ хэсгээс их агууламжтай бүсийн талбайгаар тооцож тодорхойлов. Стандартаас 2 дахин буурахаар агаарын чанарын цэвэр индекстэй ангилалд орно. Уурхайн нийт үйл ажиллагаанаас орчны агаарын чанарт нөлөөллөх бүсийн хэмжээ уурхай орчмын 60 га талбайг хамарч байна.

| Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа | Болзошгүй нөлөөлөл |
|---|---|
| Уурхайн тээвэрлэлт | Уурхайн хүнд машин механизмын хөдөлгөөний улмаас агаарт хорт хий цацагдаж агаарын чанарт сөргөөр нөлөөлнө. |
| Тээвэрлэлт | Хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөр хөрсөн бүрхэвч элэгдэлд орж, сул шороо үүссэнээр тоосжилт ихсэж агаарын чанар сөргөөр нөлөөлнө. |
| Шатахуун хадгалах, түгээх | ШТС-ын үйл ажиллагааны явцад шатах тослох материал асгарах, алдагдах зэргээр агаарын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй. |
| Тэсэлгээний ажил | Уулын чулуулгийг тэслэхэд “Тоосжсон үүл” үүсэж, тэсэлгээний орчноос гадагшлан салхинд туугдаж тархана. Математик загварчлалын судалгаанаас үзэхэд, тэсэлгээ хийснээс хойш 30-45 секундийн дараа “тоосжсон үүл” үүсэж, дараагийн 60-120 секундэд түүний томоохон хэсгүүд 0,1- 0,05 фракц газарт унана. |

## Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уурхай ашиглалтын явцад тээвэрлэлт, химийн бодисын агуулах, хөрсний овоолго зэргээс хөрсөн бүрхэвчид нөлөөлөл үзүүлэхээр байна. Тухайлбал:

- Уурхайн хүнд машин механизмын хөдөлгөөний улмаас хөрсөн бүрхэвч элэгдэл, эвдрэлд өртөнө.
- Ил уурхайн ашиглалтын явцад хөрс зайлуулагдана.
- Уурхайн олборлолтын нөлөөгөөр хөрсний овоол болон бусад овоолгуудад хөрсөн бүрхэвч удаан хугацаанд дарагдаж үндсэн хэв шинжийг алдана.

*Хүснэгт№ 6. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл*

| Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа | Болзошгүй нөлөөлөл |
|---|---|
| Уурхайн тээвэрлэлт | Уурхайн тээвэрлэлтийн нөлөөгөөр хөрсөн бүрхэвч элэгдэл эвдрэлд өртөнө. |
| Ил уурхайн үйл ажиллагаа | Ил уурхайн ашиглалтын явцад нийт хөрс эврдэлд орно. |
| Хөрсний овоолго | Уурхайн ашиглалтын хугацаанд овоолгын хөрс удаан дарагдаж, үндсэн хэв шинжийг алдаж болзошгүй |
| Засвар үйлчилгээ | Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс бохирдож болзошгүй. |
| Уурхайн барилга байгууламж | Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, хөрсөн бүрхэвч үндсэн хэв шинжийг алдана. |

*Хүснэгт№ 7. Газрын гадарга газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл*

| Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа | Болзошгүй нөлөөлөл |
|---|---|
| Уурхайн олборлолт | Газрын хэвлийн үндсэн төрхийг өөрчилнө. |
| Уурхайн дэд бүтцийн барилга байгууламж | Уурхайн дэд бүтцийн барилга байгууламжийн нөлөөгөөр газрын гадарга эвдрэлд орох. |
| Засвар үйлчилгээ | Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас газрын гадарга бохирдож болзошгүй. |
| Уурхайн тээвэрлэлт | Уурхайн хүнд машин механизмын хөдөлгөөний улмаас газрын гадарга элэгдэл, эвдрэлт өртөнө. |

## Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Шууд болон дам нөлөөлөлд өртөж энэ орчмын ургамлан нөмрөг устаж үгүй болохоос гадна ойр орчмын ургамлан нөмрөгийн био бүтээмж буурах, ургамлын төрөл зүйл цөөрөх, хөл газрын ургамал буюу хогийн ургамлын төрөл зүйл олшрох зэрэг дам нөлөөллүүд гарна.

Алаг Цав уурхайн ашиглалтын явцад дараах үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт сөрөг нөлөөллийг үзүүлж болзошгүй. Үүнд:

- Уурхайн тээвэрлэлтийн үйл ажиллагааны нөлөөгөөр ургамлан нөмрөгийн фотосинтезийн идэвхтэй туяа шингээлтийг бууруулна.
- Зарим төрлийн ургамал устаж үгүй болно

*ХүснэгтNº 8. Ургамлан нөмрөг үзүүлэх сөрөг нөлөөлөл*

| Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа | Болзошгүй нөлөөлөл |
|---|---|
| Уурхайн тээвэрлэлт | Машин техникээс ялгарах утаа, олон төрлийн хүнд элементүүд тухайн орчны 15-50м зай доторх ургамлан нөмрөгийн фотосинтезийн идэвхтэй туяа шингээлтийг бууруулна. |
| Уурхайн барилга байгууламж | Талбайн ургамлан нөмрөг дарагдаж, үндсэн хэв шинж чанараа алдана. |
| Ил уурхайн үйл ажиллагаа | Төслийн үйл ажиллагаанаас үүдэн талбайн ургамлан нөмрөг хуулагдах, устаж үгүй болох |
| Засвар үйлчилгээ | Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралт үүсэж ургамлан нөмрөгийг бохирдуулах |
| Уурхайн тээвэрлэлт | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нөлөөгөөр ургамлан нөмрөг талхагдалорж доройтох |

*ХүснэгтNº 9. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл*

| Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа | Болзошгүй нөлөөлөл |
|---|---|
| Засвар үйлчилгээ | Төслийн талбайгаар дайран урсах хур борoo, үерийн усны хяналтгүй урсцын улмаас төслийн талбай дахь аюултай болон хортой химийн бодисууд хадгалж, ашиглаж буй байгууламжууд, бохирдсон талбай, шатахуун, тослох материал, барилгын материалын үлдэгдлүүд угаагдаж, зөөгдөн гадаргын болон газрын доорх усны чанар, найрлагад сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй |

| Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа | Болзошгүй нөлөөлөл |
|---|---|
| Унд ахуйн усны хэрэглээ | Ажилчдын унд ахуйн хэрэглээний зориулалтаар ус ашигласнаар газрын доорх усны нөөц багасах боломжтой. |

## Амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөлөл:

Уурхайн ашиглалтын явцад машин техникийн дуу чимээ, ажилчдын хөл хөдөлгөөн нэмэгдсэнээс, тоос шороо, техникийн шатахууны үнэр, уурхайгаас гарч буй газрын доорх хий зэрэг нь амьд амьтан тэнд байх нөхцөлгүй болохоос гадна уурхайн тэсэлгээний үед үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн зэрлэг амьтдад шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, бэлчээр, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

*Хүснэгт№ 10.Амьтны аймаг үзүүлэх сөрөг нөлөөлөл*

| Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа | Болзошгүй нөлөөлөл |
|---|---|
| Уурхайн үйл ажиллагаа | Техноген болон хүний өөрчилсөн орчинтой холбоотойгоор зарим нэг шинэ зүйлийн шавьжнуудын тоо толгой өсөж болох |
| Уурхайн үйл ажиллагаа | Уурхайн нүх, малталт суваг шуудуунд мал, амьтан унах, ялангуяа салхи шуурганд уруудсан мал олноороо унаж сүйдэх |
| Уурхайн үйл ажиллагаа | Хөрсөнд амьдрах бичил биет организмуудын амьдрах орчин алдагдана. |
| Хууль бус ан | Хууль бус ангийн улмаас зэрлэг ан амьтдын тоо толгой бууpч болзошгүй. |
| Уурхайн дотоод тээвэр | Уурхайн дотоод тээвэрлэлтийн улмаас тоосжилт үүсэх нь агаарын чанарт сөргөөр нөлөөлж тухайн орчимд амьдрах амьтны аймагт шууд бусаар сөрөг нөлөөллийг үзүүлнэ. |
| Уурхайн гадаад тээвэр | Уурхайн гадаад тээвэрлэлтийн улмаас амьдрах орчин сүйтгэх |
| Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас амьтдын амьдрах орчин алдагдах, идэш тэжээлийн хэлхээ алдагдаж болзошгүй. |
| Тэсэлгээний ажил | Уурхайн тэсэлгээний үед үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн зэрлэг амьтдад шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, бэлчээр, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ. |

## Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

*Хүснэгт№ 11. Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, төг | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | | | | | | | | | |
| 5.1.1 | Тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөс агаарт тоосжилт бий болох | Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор технологийн зам, талбайд усалгаа хийх | Уурхайн технологийн зам, туслах замууд, зогсоолын талбай, НАБТ | | 1000,0 | | 1000,0 | Төсөл хэрэгжих хугацаанд | "Агаарын тухай" болон "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль; MNS 4585:2016 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 5885:2008 |
| 5.1.2 | | Уурхайн технологийн зам талбай, замын эргэлт уулзвар тоос их босох газруудад хайрган дэвсэлт хийх | Уурхайн уулзвар, эргэлт тойруу | | 1000,0 | | 1000,0 | Жилийн турш | |
| 5.1.3 | | Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хурдны хязгаарыг мөрдүүлэх, хяналт тавих | Уурхайн бүс | | 0,0 | | 0,0 | Төсөл хэрэгжих хугацаанд | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.4 | Тээврийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн хөдөлгүүрээс ялгарах утаа агаарыг бохирдуулах | Өвлийн улиралд халаалтын нам даралтын зууханд шүүлтүүр байршуулах | Ажилчдын хотхон-уурын зуух | 1 удаа | 1500,0 | Жилд 1 удаа | 1500,0 | Төсөл хэрэгжих хугацаанд | "Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага" MNS ISO 4227:2002 "Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө" MNS 6063:2010 "Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ" |
| 5.1.5 | Нүүрсний өөрөө шаталтаас үүдэн агаар бохирдох | Нүүрсний өөрөө шаталтаас урьдчилан сэргийлэх, шаталт (уйгалт) үүссэн тохиолдолд унтраах арга хэмжээ авах | Уурхайн талбай, нүүрсний агуулах | | 0,0 | | 0,0 | Төсөл хэрэгжих хугацаанд | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.2 Гадаргын болон газрын доорхи усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | | | | | | | | | |
| 5.2.1 | Ариг гамгүй усны хэт их хэрэглээнээс газар доорх усны нөөц **хомсдох** | Сар бүр уурхайн ус ашиглалтыг байгаль орчны байцаагчид ашиглсан мэдээг өгч, акт үйлдэх | Хотхон, уурхайн худаг, шүүрлийн ус | Удаа | 0,0 | 2 | Үйл ажиллагаа ны зардалд | Төсөл хэрэгжих хугацаанд | |
| 5.2.2 | | Уурхайн гүний худагт барилга байгууламж, бүтэн хашаа хийх, засвар үйлчилгээ хийж байх | Хотхон, уурхайн худаг | ш | 1000,0 | 1 | 1000,0 | Төсөл хэрэгжих хугацаанд | |
| 5.2.3 | | Усны зохистой хэрэглээний талаарх сургалт явуулах | Нийт ажилчдад | Удаа | 0,0 | 1 | 0,0 | Улирал бүр | Усны тухай хууль |
| 5.2.4 | Газрын доорх усны нөөцөд бохирдол үүсэх | Ашиглалтын худаг, нөлөөллийн бүсийн ойр орчимд хог хаягдлаар ус бохирдохоос сэргийлж цэвэрлэгээ хийх | Ашиглалтын худаг, нөлөөллийн бүс, тээврийн зам дагуу | Удаа | - | 2 | Үйл ажиллагаа ны зардалд | Улирал бүр | Усны тухай хууль |
| 5.3 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | | | | | | | | | |
| 5.3.1 | Хөрсөн бүрхэвч элэгдэл эвдрэлд орохоос урьдчилан сэргийлэх | Олон салаа зам үүсч хөрс, ургамал талхлагдахаас урьдчилан сэргийлж замын тэмдэг байршуулах | Уурхайн лицензийн талбай, нөлөөллийн бүс | Удаа | 500,0 | 12 | 500,0 | Тухай бүрт | Байгаль орчныг хамгаалах тухай хууль |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.3.2 | Хөрс бохирдохоос сэргийлэх | Дулааны улиралд ариутгал халдваргүйжүүлэлт хийж микробиологийн бохирдлоос урьдчилан сэргийлэх. | Ажилдчын хотхон, хатуу хог хаягдлын цэг, ахуйн шингэн хаягдал хуримтлуулах цэгийн орчинд | | 0,0 | 4 | 0,0 | Тухайн жилд | |
| 5.3.3 | Нефть бүтээгдэхүү нээр хөрс бохирдох | Хөрсөнд ШТМ-ын бохирдол үүсэхээс сэргийлж ШТМ-ын агуулах, аюултай хог хаягдлын түр цэг, Засварын газрыг цементэн хучилттай болгох | Төслийн талбайд | ш | 1000,0 | 5 | 1000,0 | Тухайн жилд | Хог хаягдлын тухай хууль |
| 5.3.4 | Шимт хөрсний хуулалт, хадгалалт | Газрыг эвдрэлд орохоос өмнө болон шимт хөрс хуулсны дараа фото зураг авч баримтжуулах, талбайн хэмжилт хийх | Уурхайн лицензийн талбай | | 0,0 | | 0,0 | Тухайн жилд | MNS 5914:2008 стандарт |
| 5.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | | | | | | | | | |
| 5.4.1 | Уурхайн нөлөөллийн бүсэд өртөж байгаа ургамлан | Олон салаа зам гаргахаас сэргийлж дотоод замуудыг маршрут гаргаж батлуулах, маршрутгүй замаар явахыг хориглох | Уурхайн нөлөөллийн бүс | Удаа | 500,0 | Сар бүр | 500,0 | Тухайн жилд | Байгалийн ургамлын тухай |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.4.2 | нөмрөгийг хамгаалах | Цаашид шинээр барилга байгууламж барих, нүүрсний талбай засах зэрэгт ортох ховор болон эмийн ашигт ургамлыг нүүлгэн шилжүүлэх замаар хамгаалах. | Уурхайн талбайд | Тухай бүр | 0,0 | | 0,0 | Тухайн жилд | БОННҮ-ний тайлан |
| 5.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | | | | | | | | | |
| 5.5.1 | Ан амьтныг хамгаалах арга хэмжээ | Тээврийн замд туруутан амьтан дайрагдахаас сэргийлж хурд сааруулагч, хурдны хязгаарын тэмдэг байршуулах | Нүүрс тээврийн зам | ш | 1500,0 | 2 | 1500,0 | 2-р улиралд | Амьтны тухай хууль |
| 5.5.2. | | Ган зудтай үед аймгийн Байгаль орчны газар, Мандах сумаас өгсөн зөвлөмжийн дагуу зэрлэг ан амьтдад заагдсан газар мөс, өвс тавьж өгөх байршуулах | Мандах сумын нутаг дэвсгэр | | 2000,0 | | 2000,0 | | |
| 5.5.2 | | | | | | | | | |
| **5.5.3.** | Шувуу цахилгаан хүчдэлд цохиулахаас сэргийлэх | Цахилгааны шугам, дэд станц дагуу шувууд цахилгаанд цохиулах, утас | Цахилгаан шугам, ил уурхай | Удаа | 500,0 | 4 | 500,0 | Улирал бүр | БОННҮ-ний тайлан |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мөргөж эндэхээс урьдчилан сэргийлж шувуу үргээгч байршуулах | | | | | | | |
| 5.6. Физик бохирдол, дуу шуугианаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр | | | | | | | | | |
| 5.6.1. | | Дуу шуугианы хэмжилт хийх | Хотхон, Ил уурхай, нүүрс баяжуулах үйлдвэр | Удаа | 250,0 | 1 | 250,0 | Жилдээ | БОННҮ-ний тайлан |
| | **Нийт** | | | | | | **13750,0** | | |

# 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээлтээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэх болно.

- Үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
- Техникийн нөхөн сэргээлт
- Биологийн нөхөн сэргээлт

## Эвдрэлд орох талбайн хэмжээ

2026 онд уурхайн үйл ажиллагаанаас эвдрэлд орох талбай нь үржил шимт хөрсийг төслийн талбайд тархах хөрс тус бүрийн морфологи бичиглэлээс үүдэн үржил шимт хөрсийг 0,2-0,3 м-ийн зузаантай хуулж, стандартын дагуу дагуу хадгална.

### 6.1. Техникийн нөхөн сэргээлт

2026 онд Алаг Цав уурхайн олборлолтын үйл ажиллагаагаар эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг уурхайн ашиглагдахгүй хаягдал хөрсний овоолгыг хэлбэржүүлж хийнэ. Нийт 3 га талбайд хийгдэнэ.



*Зураг№ 4. Техникийн нөхөн сэргээлт хийх төлөвлөлт*

**Шимт хөрс хуулалт:**

Шимт хөрсний овоолгыг газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008 стандартын дагуу хуулж, хадгална.

Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, усанд автах, хужиртах, хатуу биет, чулуу, барилгын болон хаягдалд дарагдаж бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлнэ.

Шимт хөрсний овоолгын байршил, хэлбэр, хэмжээ нь түүний хамгийн сайн хадгалагдах нөхцөлийг хангасан байхаар хэлбэршүүлэх бөгөөд шимт хөрсний овоолгын өндрийг 5 метрээс илүүгүй, салхины ноёлох чиглэлийн дагуу үүсгэнэ.

Шимт хөрсийг 2 жилээс дээш хадгалах шаардлагатай тул шимт хөрсний овоолгын гадна талаар Шимт хөрсний хадгалалт, хамгаалалт, тордлогоо, бүртгэл, хяналтын ажлыг байнга хэрэгжүүлнэ. MNS 5918:2023 стандартын дагуу шимт хөрсний ургамалжуулалт болон өнгөн хэсгийг хийсэхээс хамгаалах арга хэмжээг авна.

**6.2. Биологийн нөхөн сэргээлт, туршилт**

2026 онд биологийн нөхөн сэргээлт ажил хийгдэхгүй. Зөвхөн биологийн нөхөн сэргээлтэд ашиглах ургамлын туршилтын ажил хийгдэнэ.

2027 онд биологийн нөхөн сэргээлт хийх талбайг бэлтгэх, шимт хөрсийг биологийн нөхөн сэргээлтэд ашиглахын өмнө хөрсний үржил шим, физик химийн үзүүлэлт, хөрсний механик бүрэлдэхүүн, хүнд металлуудын шинжилгээг хийж нөхөн сэргээлтэд шууд хэрэглэхэд тохиромжтой эсэхийг зайлшгүй шинжилнэ.

Хэрэв хучилт хийхэд тохиромжтой үзүүлэлтийг хангахгүй тохиолдолд хөрсний үр шимийг сайжруулах эрдэс болон шимт бордоо хэрэглэх зэрэг арга хэмжээ авна.

Биологийн нөхөн сэргээлтэд тухайн орон нутгийн ургамлын үрийг сонгохын зэрэгцээ нөмөрлөг болон тухайн бүс нутагт ургах эрчим сайтай үрийн нөөц арвинтай ургамлыг сонгох нь үр дүнтэй.

*Хүснэгт№ 12.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө*

| № | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **6.1** | **Техникийн нөхөн сэргээлт** | | | | | | | |
| 6.1 | | хаягдал хөрсний овоолгоп техникийн нөхөн сэргээлт хэлбэржүүлэх | 3 га | 0,0 | 3000,0 | 3000,0 | Тухайн жилд | MNS 5918:2023 стандарт |
| **6.2** | **Биологийн нөхөн сэргээлт** | | | | | | | |
| 6.2. | Шимт хөрсний овоолгыг хөрсний үржил шимийг хадгалах | Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэхээс сэргийлж өнгөн хэсгийг хамгаалах | га | | 1000.0 | 1000.0 | Жилд 1 удаа | MNS 5918:2023 стандарт |
| 6.3. | Хөрсний овоолгод биологийн нөхөн сэргээлтэд ашиглах ургамлын туршилт хийх | Туршилтын талбай байгуулан нутгийн ургамал тарих | га | 0.5 | 2000.0 | 2000.0 | Жилд 1 удаа | MNS 5918:2023 стандарт |
| | **Нийт** | | | | | **6000,0** | | |

# 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

***Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зорилго:*** Гадаргын усны хомсдолтой бүс нутагт амьдардаг малчин өрхийн усны эх үүсвэр болох гар худгууд байрладаг булаг, шандтай газруудыг нөхөн сэргээх, усны ундаргыг хамгаалах, иргэдэд байгаль орчныг хамгаалах боловсрол олгох, Нэг тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлнэ. "Их Түмэн Хүрд"ХХК нь орон нутгийн иргэдээс ирсэн хүсэлтийн дагуу малчин өрхүүдтэй хамтран ногоон байгууламж бий болгох бөгөөд модны суулгацыг төслийн ажилчдын хотхонд байгуулсан модны суулгацын талбайгаас зөөвөрлөн нутгийн иргэдтэй хамтран тариалалт хийж хамгаалах арга хэмжээ авна. Тариалалт хийснээс хойшхи усалгаа, арчилгааг нутгийн иргэд гүйцэтгэх бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь хяналт тавьж ажиллана.




*Зураг№ 5. Дүйцүүлэн хамгаалалт хийхээр төлөвлөж буй газрын байршил*

Хүснэгт№ 13.Дүйцүүлэн хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд

| № | Дүйцүүлэн хамгаалах зорилт | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 7.1.1 | Орон иргэдийг ногоон байгууламжтай болгох | Мандах сумын II багийн малчин Ариунболдтой хамтран төслийн талбайн хойно 5 км зайд, Арван наймын богд уулын урд Шавартын булаг нэртэй газар 0.5 га талбайд ногоон байгууламжтай болгох | | 1 удаа | 3000,0 | 3000,0 | 2-р улирал | БОННҮ-ний тухай хууль, "Түмэн айл" чулуун нүүрсний ордын баруун урд жигүүрийг ил аргаар ашиглах төслийн БОННҮ |
| **7.1.2** | Тэрбум мод хөтөлбөр | Нэг тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд жил бүр 2000 суулгац тарих, услагаа, арчилгаа тогтмол хийх. | | 1-2 удаа | 5000,0 | 5000,0 | | БОННҮ-ний тухай хууль, "Түмэн айл" чулуун нүүрсний ордын баруун урд жигүүрийг ил аргаар ашиглах төслийн БОННҮ |
| **7.1.3** | Арваннайм ын богд уул БНГ-ын биологийн олон янз байдлыг хамгаалах | Зэрлэг ан амьтан услах мэдрэгчтэй гүний худаг гаргах, арчлах | | | 5000,0 | 5000,0 | | БОННҮ-ний тухай хууль, "Түмэн айл" чулуун нүүрсний ордын баруун урд жигүүрийг ил аргаар ашиглах төслийн БОННҮ |
| | **Нийт** | | | | | **13000,0** | | |

## 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор арга хэмжээ төлөвлөгдөөгүй. Нөлөөллийн бүсийн айл, өрхүүдтэй хамтран ажиллаж ган, зуд, цаг агаарын нөхцөл хүндэрсэн тохиолдолд шаардлагатай тусламж, дэмжлэгийг үзүүлнэ.

*Хүснэгт№ 14.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ*

| № | Нүүлгэн шилжүүлэх зорилт | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 8.1 | | | | | | | | |
| | Нийт | | | | | 0,0 | | |

## 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

"Их Түмэн Хүрд"ХХК нь 2017 онд төслийн талбайд археологи, палеонтологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажил гүйцэтгүүлсэн. MV-021559 тоот талбайд археологи, палеонтологийн дурсгал байхгүй болно. "Их Түмэн Хүрд"ХХК нь дээрх олдворуудыг хянах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран хамгаалах арга хэмжээг авна.

*Хүснэгт№ 15. Түүх соёлын өвийг хамагаалах арга хэмжээ*

| № | Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **9.1.** | Түүхийн дурсгалт зүйлсийг хамгаалах арга хэмжээ | Уурхайн үйл ажиллагаагаар археологи, палеонтологийн олдвор, дурсгалт зүйл илэрсэн тохиолдолд Соёлын өвийн тухай хуульд заасны дагуу холбогдох газарт мэдээлэх | Лизензийн талбай дотор | | | Үйл ажиллагааны зардалд туссан | Тухайн жилд | Соёлын өвийн тухай хууль |
| | Нийт | | | | | 0,0 | | |

## 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт№ 16. Осол эрсдэлийн менежментийн төлловлөгөө*

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 10.1. | Ил уурхайд үүсч болзошгүй эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ | Ил уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж батлуулж мөрдөн ажиллах | Алаг Цав төсөл | 1 | 500,0 | 500,0 | 1-р улирал | Гамшгаас хамгаалах тухай хууль, Ил уурхайн АУХТ |
| 10.2 | Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга | Галын дүгнэлт гаргуулах | 3,4 амны уурхай | 1 | 500,0 | 500,0 | 1-р улирал | Гамшгаас хамгаалах тухай хууль, Ил уурхайн АУХТ |
| 10.3 | | Галын хор, галын багаж хэрэгслийн бүрэн бүтэн, ажиллагаатай эсэхийг сар бүр шалгаж байх | 3,4 амны уурхай | | 0,0 | 0,0 | | Гамшгаас хамгаалах тухай хууль, Ил уурхайн АУХТ |
| 10.4 | | Нүүрсний шаталт, уугилт гарах эрсдэлээс сэргийлж үзлэг тогтмол хийх, богино хугацаанд бүрэн унтраах техникийн бэлэн байдлыг хангах | Алаг Цав төслийн хэмжээнд 3,4-р амны уурхай | | 500,0 | 500,0 | Тухай бүр | |
| 10.5 | ШТМ-аас байгаль орчин бохирдох | Техникүүдийн засвар үйлчилгээ, РМ үйлчилгээ (250, 500, 1000 мото/цаг) тогтмол хийж асгаралт үүсэхээс сэргийлэх, ШТМ-ын талбайг цементлэх | Алаг Цав төслийн хэмжээнд 3,4-р амны уурхай | 4 | 1500,0 | 1500,0 | Улирал бүр | Гамшгаас хамгаалах тухай хууль, Ил уурхайн АУХТ |
| 10.6 | Байгаль цаг уураас үүсэх эрсдэл | Цасан шуурга болон үерийн дараа уурхайн тээвэрлэлт хийдэг тээврийн замууд, | Алаг Цав төслийн хэмжээнд | | 500,0 | 500,0 | Жилийн турш | Төслийн эрсдэлийн менежмент төлөвлөгөө, |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | уурхайд ирэх, буцах аяллын зам эвдрэлд орсон эсэхийг шалгах, засах сайжруулах | 3,4-р амны уурхай | | | | | Гамгшгаас хамгаалах тухай хууль |
| **10.8** | Онцгой байдлын бэлэн байдал | Болзошгүй аваар ослын үед аврах багийн бэлэн байдлыг хангах,анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариа, шаардлагатай бусад нөөцийг бэлэн байдалд байлгах | Алаг Цав төсөл | | 1500,0 | 1500,0 | | БОННҮ-ний тайлан |
| **10.9** | Сургалт, зөвлөгөө | ХЭБЭА-н хууль тогтоомж, дүрэм журмын сургалт, өдөр тутам, анхан шат, давтан зааварчилгаар Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм MNS 4969:2000 стандартын дагуу зохион байгуулах | Сард | | 0,0 | 0,0 | | БОННҮ-ний тайлан |
| | Ажилчдыг НБХХ-ээр хангах | Ажиллагсдад тооснoос хамгаалах хушуувч, амны маск, нүдний шил, бээлий зэрэг ХХХ-р хангах | жилд | | 1500,0 | 1500,0 | | |
| | **Нийт** | | | | **6500,0** | | | |

# 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Аливаа төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, ажилчдын хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх, хог хаягдлыг бууруулах, ангилах, зүй зохистой түр хадгалах, дахин ашиглах нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах үндсэн үүргийн нэг юм.

"Их Түмэн Хүрд"ХХК нь төслийн үйл ажиллагаанаас үүсч байгаа энгийн болон аюултай хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг жил бүрийн байгаль орчны менементийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх шаардлагатай.

- Мандах сумын нэгдсэн хогийн цэгт тээвэрлэж устгах гэрээг зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй хийж уурхайн үйл ажиллаганаас гарч буй энгийн 20 тн орчим хог хаягдлыг ландфилдэж устгана.
- Аюултай хог хаягдал цуглуулах тээвэрлэх, устгах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид хаягдал шилжүүлэн өгөх гэрээг **"ОБ ОЙЛ ИНДАСТРИАЛ ХХК-**тай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. 2026 онд техникийн засвар үйлчилгээ, бусад үйл ажиллагаанаас гарах аюултай хаягдал  тосны тээвэрлэлтийг хийлгэж дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлнэ. Нийт 10 тонн орчим аюултай хог хаягдал гарна.
- Дахивар хог хаягдлыг зориулалтын хогийн сав, түр цэгт ангилан ялгаж түр хадгалж дахин болосвсруулах үйлдвэрт нийлүүлнэ.
- Уурхайн талбайн ойр орчим, худаг уст цэг, тээврийн замын дагуу нийтийн хог хаягдлыг цэвэрлэгээ хийж, гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт нийлүүлнэ.
- Шингэн хог хаягдлыг байгальд хаях усны стандартад нийцүүлэн цэвэрлэж хаягдлын цэгт хаяна.

*Хүснэгт№ 17. Хог хаягдлын менежмент*

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгж ийн зардал, төг | Тоо хэмжээ | Нийт зардал, (төг) | Хэрэгжүүлэх хугацаа | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 11.1.1 | 11.1 Энгийн хог хаягдал | Ахуйн хатуу хог хаягдал түр хадгалах цэг засаж тохижуулах, ангилан ялгалт хийсэн савнууд байршуулах, засвар, шинэчлэлт тогтмол хийх | 3,4-р амны уурхайн хотхон, бусад байршлууд | ш | 500,0 | 4 | 500,0 | Төсөл хэрэгжих хугацаанд | Хог хаягдлын тухай хууль |
| 11.1.2 | | Уурхай, нөлөөллийн бүсэд нийтийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хог хаягдал цэвэрлэгээ зохион байгуулах | Лицензийн талбай, нөлөөллийн бүс | | 500,0 | 4 | 500,0 | Төсөл хэрэгжих хугацаанд | Хог хаягдлын тухай хууль |
| 11.1.3 | | Хогийн цэгт дулааны улиралд ариутгал халдваргүйжүүлэлт хийж байх | Ажилчдын хотхон, уурхай | - | - | - | 300,0 | Төсөл хэрэгжих хугацаанд | Хог хаягдлын тухай хууль |
| 11.1.4 | | Хог хаягдлын бүртгэл хөтлөх, дахивар хүлээн авагчийг судалж хаягдлын төрөл бүрээр нийлүүлэх | Ажилчдын хотхон, уурхай | - | - | - | Үйл ажиллагааны зардалд туссан | Төсөл хэрэгжих хугацаанд | Хог хаягдлын тухай хууль |
| 11.1.5 | | Жилд 1 удаа хог хаягдлын сургалт орох | Ажилчид болон тээврийн машины жолооч нарт жилд | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11.2.1 | 11.2. Аюултай хог хаягдал | Ашигласан тос масло түр хадгалах зориулалтын цэг байгуулах, хатуу хучилт, хаяг, хашаа хийх. | Туслан гүйцэтгэгч компанийн ажилчдын хотхон | - | - | - | Үйл ажиллагааны зардалд туссан | Тухайн жилд | |
| 11.2.2 | | Уурхайн хэмжээнд тогтмол гардаг тосны шүүр, бохирдсон материал, шингээгч, тос шингэсэн асгаралтын бүрдэл хуванцар тосны сав баглаа боодлыг аюултай хог хаягдал зайлуулах, устгах мэргэжлийн байгууллагад нийлүүлэх | Төслийн талбай | 2 удаа | 3500,0 | - | 3500,0 | Тухайн жилд | |
| 11.2.3 | | Эмнэлгийн хог хаягдлыг сумын эмнэлэгтэй гэрээ байгуулан устгах | Төслийн талбай | - | 500,0 | - | 500,0 | Тухайн жилд | |
| 11.2.4 | Аюултай шингэн хаягдал | Шингэн хаягдал цэвэршүүлэх байгууламжын орчинд дулааны улиралд ариутгал халдваргүйжүүлэлт хийж микробиологийн бохирдлоос урьдчилан сэргийлэх | Төслийн талбай | | 300,0 | | 300,0 | | |
| 11.2.4 | | Шингэн хаягдлын цэвэрлэх байгууламжын засвар үйлчилгээг тогтмол хийлгэх, агаарын хоолой, шүүлтүүр цэвэрлүүлэх | 3,4 амны цэвэрлэх байгууламж | | 1000,0 | | 1000,0 | | |
| | **Нийт** | | | | | | **6600,0** | | |

# 12.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

"Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 3.1 дүгээр зүйл, "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуульд зааснаар төслийг хэрэгжүүлэх явцад төслөөс байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) гэнэ.

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр нь төсөл хэрэгжиж буй бүс нутагт гарч болзошгүй өөрчлөлтүүдийг эрт тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг тайлагнах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, нутгийн оршин суугчдад байгаль орчин, амьдрах орчны өөрчлөлтийн талаар бодит мэдээлэл өгөх үндсэн зорилготой.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дэвсгэрт байрлах нүүрсний ордыг олборлохоор "Их Түмэн Хүрд" ХХК-аас хэрэгжүүлж байгаа Алаг Цав төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй сөрөг нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгаж хяналт тавих нь зүйтэй. Хяналт шинжилгээг дараах цэгүүдэд хийхээр төлөвлөгөөг боловсрууллаа.

### 12.1. Агаарын чанарын хяналт шинжилгээ

*Хүснэгт№ 18. Агаарын чанарын хяналт шинжилгээ*

| Бүлэг | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төгрөг | Тайлбар | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12.1.1 | Агаар дахь NO2, SO2, CO2, PM2.5, PM10-ийн агууламж | Ажилчдын хотхон, нүүрсний талбай, зам, нөлөөллийн бүс | Жилд | 2 удаа | 1000,0 | 1000,0 | Мэргэжлийн байгууллагаар хийлгэх. | "Агаарын тухай" болон "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль; MNS 4585:2016 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 5885:2008 "Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага" MNS ISO 4227:2002 "Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө" MNS 6063:2010 |
| 12.1.2 | Агаар бохирдуулагчийн шинжилгээ (Нүүрстөрөгчийн исэл $C0_2$, хүхэрт устөрөгч $SO_2$, азотын давхар исэл $NO_2$) | Засварын шоп Шатахуун түгээх станц | Жилд | 2 удаа | 1000,0 | 1000,0 | Мэргэжлийн байгууллагаар хийлгэх | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12.1.4 | Дуу шуугиан (гадаад орчны дуу шуугианы түвшин) | Карьер, Засварын талбай, ажилчдын хотхон, технологийн зам | Жилийн турш | 4 удаа | - | Үйл ажиллагааны зардалд туссан | | MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага |
| | **Нийт** | | | | **2000,0** | | | |

**12.2. Усны чанарын хяналт шинжилгээ**

*Хүснэгт№ 19.Усны чанарын хяналт шинжилгээ*

| Бүлэг | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төгрөг | Тайлбар | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12.2.1 | Ундны ус. аюулгүй байдлыг хянах | -Ундны ахуйн хэрэглээний усны худаг, -Уурхайн ашиглалтын худаг - Малчны худаг | Улиралд 1удаа | 4 | 150,0 | 600,0 | Дээжийг итгэмжлэгдсэн лабораторит хийлгэх | MNS 0900:2018 ''Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ'' |
| 12.2.2 | -Ундны усны Ерөнхий химийн шинжилгээ | Гүний худгийн усны дээж, Шүүрлийн ус, малчдын худаг | Улиралд 1удаа | 4 | 150,0 | 600,0 | Дээжийг итгэмжлэгдсэн лабораторит хийлгэх | MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS 4943:2015 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12.2.3 | Бохир усны шинжилгээ | 3,4- амны кемпийн цэвэрлэх байгууламж | 6 сард 1 удаа | 2 | 300,0 | 600,0 | Мэргэжлийн байгууллагаар хийлгэх. | Хаягдал ус, техникийн ерөнхий шаардлага MNS 4943 : 2015 |
| | Нийт | | | | 1800.0 | | | |

**12.3. Хөрсний хяналт шинжилгээ**

*Хүснэгт№ 20. Хөрс, ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээ*

| Бүлэг | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төгрөг | Тайлбар | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12.3.1 | Хөрсний үржил шимийн үзүүлэлт (pH, ялзмаг, карбонат, $Ca^{2+}Mg^{2+}$, K2O, P2O5)<br>-Хүнд металлууд (Cr, Pb, Cd,Ni Zn)<br>-Микробиологи | Хог хаягдлын цэгүүд, ажилчдын хотхон, нүүрсний талбай, зам | Улиралд 1 удаа | 4 | 150,0 | 600,0 | Гэрээт лабораторид шинжлүүлнэ | Хөрс, шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS 3298:1991 |
| 12.3.2 | Урт хугацаанд хадгалагдах шимт хөрсний физик, хими, үржил шимт чанарын үзүүлэлтүүд | - Шимт хөрсний овоолгоос дээж авах<br>-Нөлөөлөд өртөөгүй талбайн шимт хөрснөөс дээж авах | Жилд | 2 | 200,0 | 400,0 | Гэрээт лабораторид шинжлүүлнэ | |
| | Нийт | | | | 1000.0 | | | |

**12.4. Амьтан, ургамлын мониторинг**

*Хүснэгт№ 21. Ургамал, амьтны аймгийн хяналт шинжилгээний хөтөлбөр*

| Бүлэг | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төгрөг | Тайлбар | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12.4.1 | Лицензийн талбай, нөлөөллийн бүсийн ургамлын зүйлийн бүрдлийг тодорхойлох | Лицензийн талбайд 3 цэг Нөлөөллийн бүсэд 3 цэг | Жилд | 1 удаа | 5000,0 | 5000,0 | 2-р улиралд | Байгалийн ургамлын тухай хууль Биологийн олон янз байдлын мониторинг судалгааны аргазүй |
| 12.4.2 | Ан амьтны тоо толгой, байршлын судалгааг төслийн талбай, нөлөөллийн бүсэд хийх | Уурхайн 5-10 км радиуст | 9-р сар | 1 удаа | 1000,0 | 1000,0 | Тооллого судалгаа | Тооллого хийх маягт, Зургийн аппарат, байршил тогтоогч (GPS), дрон |
| 12.4.3 | Төслийн талбайн нөлөөллийн бүсийн амьтны аймгийн амьдрах орчин, идэш тэжээлийн судалгаа, хяналт | Ажиглалт судалгаа хийх, хяналт тавих | Жилд | 1 удаа | - | Үйл ажиллагааны зардалд туссан | Хяналт, ажиглалт | Ан амьтны бүртгэлийн маягт |
| | **Нийт** | | | | | **6000,0** | | |

# 13. ТУХАЙН ЖИЛИЙНИ БОМТ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

"Алаг Цав" төслийн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны (ХАБЭАБО) хэлтэс нь 6 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Жил бүр уламжлал болон зохион байгуулдаг байгаль орчныг хамгаалах тэмдэглэлт болох Хулан хамгаалах өдрийг Мандах сумын сургуультай хамтран зохион байгуулна. Тэмдэглэлт өдрүүдээр дамжуулан компанийн ажилчид, орон нутгийн иргэд, олон нийтийг байгаль орчныг хамгаалахад уриалах, зөв дадал бий болгоход чиглэсэн ажлуудыг хийнэ.

Монгол Улсын Еренхийлөгчийн санаачлагаар хэрэгжиж буй "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Их Түмэн Хүрд" ХХК нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн дүгнэсэн зөвлөмжийн хүрээнд Дорновь аймгийн Мандах сумын нутагт Заг үржүүлэх зорилгоор хашаалсан 9 га талбайд 2025 оноос үе шаттайгаар мод тарих ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Дорноговь аймгийн хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Уг хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн хэмжээнд говь, цөлийн бүсэд загаар ойжуулах шаардлагатай газруудыг тодорхойлох болно.

*Хүснэгт№ 22. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө*

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь 2026 он | | | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сар | Сар | Сар | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 13.1 | Дэлхийн байгаль хамгаалах өдрөөр "Мандах сумын дунд сургууль"-ийн 1 ангийг байгалийн шинжлэх ухааны зориулалтаар тохижуулах | 3000,0 | 6-р сар | | | 3000,0 | Аймгийн Байгаль орчны газрын зөвлөмж |
| 13.2 | Ажилчдыг хор тайлах хүнсний нэмэлт бүтээгдэхүүн (хоомог)-ээр хангах | 3000,0 | | | | 3000,0 | |
| 13.3 | Байгаль орчны цогц сургалт | 500,0 | 4-р сар | | | 500,0 | |
| | **Нийт** | | | | | **6500,0** | |

## 14. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-ИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

*ХүснэгтNo 23. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө*

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал, төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан | Зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **14.1** | Дорноговь аймгийн Мандах сумын 1,2-р багийн иргэдэд уурхайн үйл ажиллагаа, байгаль орчны чиглэлээр хийгдэж байгаа ажлуудыг танилцуулах | Уурхайн үйл ажиллагаатай танилцуулах өдөрлөг зохион байгуулах | Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулх чиглэлээр хийгдэж байгаа ажлуудын талаар мэдээлэл өгөх | 3-р улиралд | 1000,0 | Уурхайн удирдлага, Байгаль орчны мэргэжилтэн | Алаг Цав уурхай |
| **14.2** | 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг сум, аймгийн холбогдох газруудад хүргүүлэх, тайлагнах | Хэвлэмэл тайлан, БОМТ тайланг www.eic.mn цахим сайтад байршуулах | 2025 онд байгаль орчны чиглэлээр хийгдсэн ажлууд | 4-р улирал | 0,0 | Байгаль орчны мэргэжилтэн | Дорноговь аймаг |
| **14.3.** | 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг орон нутгийн ажлын хэсэгт танилцуулах, дүгнүүлэх | Танилцуулга хийх, хийгдсэн ажлыг газар дээр нь үзүүлэх | БОМТ-ийн биелэлт, хийгдсэн ажлууд | 4-р улиралд | 500,0 | Уурхайн удирдлага, ХАБЭАБО хэлтэс | Дорногвь аймаг Мандах сум, Алаг Цав уурхай |
| | **Нийт** | | | | **1500,0** | | |

## 15. БОМТ-ИЙН НИЙТ ЗАРДАЛ

Их Түмэн Хүрд ХХК-ийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2023 онд батлагдсан БОННҮ-ний тухай хууль, “Түмэн айл” чулуун нүүрсний ордын баруун урд жигүүрийг ил аргаар ашиглах төслийн БОННҮ-ний тайланд тусгагдсан ажлууд, нэгдсэн дүгнэлт зөвлөмж, 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дүгнэх ажлын хэсгийн 2025 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлууд болон цаашид анхаарч ажиллах чиглэлийн хүрээнд боловсруулсан.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг төслийн үйл ажиллагааны зардалд бүрэн тусгаж хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөсөн.

*Хүснэгт№ 24. БОМТ-ийн зардлын дүн*

| Д/д | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө | Нийт зардал /мян.төг/ |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 13,750,0 |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 6000,0 |
| 3 | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 13,000,0 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | 0,0 |
| 5 | Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө | 0,0 |
| 6 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 6500,0 |
| 7 | Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал | 6600,0 |
| 8 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) | 11,800,0 |
| 9 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 6500,0 |
| 10 | Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө | 1500,0 |
| **Нийт зардал** | | **65,650.0** |